

ТЕЛЕВИЗҮҮДИЙН СПОРТЫН НЭВТРҮҮЛГИЙН ХЭЛ НАЙРУУЛГАД
ХИЙСЭН СУДАЛГАА

Д. Одончимэг*

*БНХАУ-ын Өвөр Монголын Их Сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн докторант

Түлхүүр үг: Спорт, мэдээ, олимп, сэтгүүлч, хэл найруулга, тэмцээн, хөтөлбөр, дархлаа, үзэгч, нэвтрүүлэг

Даяаршлын эрин үед бага буурай улс үндэстнүүдийн өмнө тулгарч байгаа бэрхшээлтэй асуудлын нэг нь үндэсний хэл соёлоо хамгаалах зорилт болж байна. Энэ асуудал нэг улс үндэстний хүрээнээс аль хэдийнээ хальж нийт хүн төрөлхтний сэтгэл зовоосон асуудал болжээ. Үүний тодорхой жишээ нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын санаачилгаар 2008 оныг дэлхийн олон улсын эх хэлний жил болгон зарлаж, түүний төрөлжсөн байгууллага болох ЮНЕСКО “Хэлний хамтлаг бүхэн өөрийн эх хэлийг аль болохоор өргөн байнга, түүний дотор боловсролын салбарт ашиглахад чиглэсэн хэлний бодлогыг хөгжүүлэх”-ийг уриалсан явдал мөн. Орчин үед үндэстний дархлааг тогтоох цорын ганц арга нь тэдгээрийн хэл ба соёлыг хамгаалах явдал гэдгийг нийтээрээ мэдэх болжээ. Тиймээс ч ЮНЕСКО “Соёлын олон төрлийг хамгаалах аргаар үндэстнийг аварна” гэсэн бодлого явуулж байгаагийн дотор дэлхийн олон хэлийг хамгаалах санаа багтаж байгаа юм. Дэлхийн олон үндэстний хэлийг хамгаалах асуудал аль хэр чухал болж байгааг дараах тоо

баримт харуулна. 2005 онд АНУ-ын Хэл шинжлэлийн институтээс гаргасан тооцоогоор дэлхий дээр 6912 хэл байгаа аж. Тэдгээрийн 6712 хэлээр нь дэлхийн хүн амын ердөө 6.0 хувь нь ярьдаг байна. Гэтэл хүн төрөлхтний 94 хувь нь ердөө л 242 хэлээр ярьдаг аж. Үүнээс үзэхэд дэлхийн хүн амын үнэмлэхүй олонх нь даяаршлын давалгаанд арчигдахын даваанд тулж очсон жижиг хэлээр ярьдаг нь тодорхой байна. Тэдгээр жижиг хэлнээс жил тутам 10-20 орчим нь устаж байгаа гэсэн тооцоо ч байдаг.

Төрөлх хэлний дархлааг хамгаалахад олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлгийн гүйцэтгэх үүрэг асар их билээ. Аль ч улс үндэстний олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд утга зохиолын хэлний “нийтлэлийн” хэмээх нэг л төрлийг журамладаг боловч, тэр нь хэрэгсэл бүхэнд адил байдаггүй. Тиймээс ч “сонины хэл”, “радиоогийн хэл”, “телевизийн хэл” гэх мэтээр ялгаа гаргаж хэлэлцдэг билээ. Энэ нь мэдээллийн хэрэгслүүд хоорондоо хатуу зааглагдсан тусгай тусгай хэлтэй байдаг гэсэн хэрэг хараахан биш, харин хэрэгсэл бүхэн бодит байдлын юмс үзэгдлийг тусгах өвөрмөц аргатай байдгаас үүдэлтэй юм. Мөн хэрэгсэл бүхэн нийгмийн тодорхой хэсэг бүлгийн

мэдээлэл, танин мэдэхүйн хэрэгцээг хангаж, харилцааны тодорхой салбарт үйлчилж байдгийн хувьд тэр бүхэнд тохирсон өвөрмөц хэл найруулгыг ашиглаж болдог гэсэн үг юм. Тэр бүхний дотроос телевизийн, тэр тусмаа спортын нэвтрүүлгийн хэл найруулгын талаар тогтож өгүүлье.

Спортын нэвтрүүлгийн хэл найруулга. Спорт бол хором, хурд, хүч юм. Сэтгүүлч хүн спортыг ингэж ойлгох ёстой. Тиймээс ч тэд хурдан хөдөлгөөн, үйл явдлын өрнөл дунд тухайн үйл явдлын мэдээг цаг хугацаатай өрсөн дамжуулахыг хичээж ажилладаг. Спорт бол хүмүүсийн хамгийн их хорхойсдог зүйлийн нэг мөн. Тиймээс ч даян дэлхийн сая сая хүмүүс өвөл, зуны олимп, олон улсын чанартай цуврал тэмцээнүүдийг амьсгаа даран үзэж суудаг. Спорт бол бас хүчирхэг бизнес мөн. Спортын түүхэнд хөлбөмбөг, бэйсбол хамгийн их ашиг орлоготой төрөл хэмээн бүртгэгджээ. Спортын клубүүд шилдэг тоглогчдыг олон сая доллароор үнэ хаялцан худалдаж авахад хэзээд бэлхэн байдаг.

Харин үзэгчдийн хувьд тэдгээр од, шилдэг тоглогчдын шийтэнд бөмбөг оруулж байгаа, марафонд түрүүлж байгаа торгон агшныг үзэхийг хүсэж байдаг. Спортын сэтгүүлч өөрөө шүтэн бишрэгч байх ёстой. Тэгэхгүй бол аливаа тоглолтын тансаг сайхан хийгээд сэтгэл догдлуулсан мөчийг мэдэрч чадахгүйд хүрнэ. Тэд спортын ертөнцөд сүүлийн үед юу болж байгаагаас эхлээд бүх зүйлийг мэддэг байх ёстой. Америкийн спортын сэтгүүлч Франк О.Брейн анхаарал татсан тоглогчдын тухай өргөн мэдээлэлтэй байхын тулд цахим хуудсуудыг нь өдөр бүр шалгадаг байжээ. Тэр бээр сайтуудаас спортын зах зээлд болж байгаа үйл явдал, санхүүгийн маргаан, бэртэж гэмтсэн

тоглогчид, тэмцээний эргэн тойрны адал явдал, шинэ дээд амжилт, тоглогчид болон дасгалжуулагчдын хоорондын хонзогнол гэх мэт олон зүйлийн мэдээллийг хайдаг байжээ. Түүнчлэн хэн нэг тоглогч тухайн долоо хоногт ямар нэг шуугианы бай болсон бол тэр мэдээлэл хамгийн түрүүнд спортын сэтгүүлчид ирэх ёстой гэж тэр үздэг байна. Спорт бол хурд, хүч гэж дээр хэлсэн. Үүнтэй адил спортын мэдээ, сурвалжилга бас шуурхай, эрчимт хэмнэлтэй байх ёстой. Ийм байдал дүрсээр төдийгүй үг хэлээр илэрхийлэгддэг.

Спортын мэдээний хэл хүнд нухацтай байх албагүй. Учир нь үзэгчдийн хувьд энэ нь ерөнхийдөө зугаацлын шинжтэй зүйл юм. Хөл бөмбөгийн тэмцээнд хэн нь хожиж, хэн нь хожигдсоноос үл хамааран үзэгч тоглоом гэдэг утгаар нь түүнийг сонирхдог. Тиймээс аль ч тэмцээний үед нөхөрсөг байдал, сонирхолтой уур амьсгал бүрдүүлэхийн хэрээр үзэгч телевизийн нэвтрүүлгийг төдий чинээ их сонирхдог. Хүмүүс спортын нэвтрүүлгүүдийг үзэх үедээ өөрсдийгөө яг тэнд байгаа мэтээр төсөөлдөг. “Галзуу” шүтэн бишрэгчид өөрийн шүтдэг багийг дэмжиж байгаагаа хүчтэй илэрхийлэхийн сацуу хөгжилтэй, бас жигшмээр зан авир гаргах нь ч бий. Тоглогчид ч заримдаа хөгжилтэй, инээдэмтэй үйл явдлын бай болох үе гардаг. Спортын сэтгүүлч тэр бүхэнд тохирсон өгүүлэмж, үг хэлээр үзэгчидтэй харилцах шаардлагатай болдог.

Манай сэтгүүлчид тийм байж чаддаг уу гэвэл учир дутагдалтай зүйл олон бий. Хормоор хэмжигдэж, хурд хүч сорьж байгаа үйл явдалтай зэрэгцэн байж, түүний уур амьсгалыг оновчтой, хөнгөн айзамтай үг хэлээр илэрхийлэх чадвар олонх тохиолдолд дутагдаж

байгаа харагддаг. Спортыг сурвалжилж байгаа сэтгүүлч наад зах нь өөрөө тамирчин шиг хувцаслаж, эрч хүчтэй, цог золбоотой харагдах ёстой. Гэтэл манайхан албаны хувцас өмсөж, зангиа зүүгээд, сэтгэлийн ямар ч хөдөлгөөнгүй мод шиг зогсож байгаад тайлбарлах нь зохимжгүй харагддаг.

Хэлний хувьд бүр ч ядуу даржин байдаг. Магадгүй, телевизийн хөтөлбөрүүдийн дотроос хамгийн муу хэл найруулгатай нь спортын нэвтрүүлэг гэж хэлж болно. Манай улсын хамгийн нэр хүндтэй, чадварлаг багтай үндэсний олон нийтийн телевизийн спортын мэдээ гэхэд л найруулгын алдаагаар дүүрэн байдаг. Үүнийг дараах жишээнүүдээр баталж болно. Тус телевизийн спортын сэтгүүлчид “Шатрын өсвөрийн дэлхийн аварга” (“Цагийн хүрд” 2018.10.15), “Самбо бөхийн өсвөр үеийн олон хотын тэмцээн” (“Цагийн хүрд” 2018.10.16), “19 хүртэлх насны Азийн аварга” (“Цагийн хүрд” 2018.11.05), “Монгол улсын хорь хүртэлх насны шигшээ баг” (“Цагийн хүрд” 2018.12.10), “Шайбтай хоккейн өсвөрийн аварга шалгаруулах тэмцээн” (“Цагийн хүрд” 2019.02.21), “Шатрын оюутны 2019 оны Улсын аварга шалгаруулах тэмцээн” (“Цагийн хүрд” 2019.03.22), “Шатрын өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээн” (“Цагийн хүрд” 2019.04.09), Боксын залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн” (“Цагийн хүрд” 2019.04.10), “Волейболын өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээн” (“Цагийн хүрд” 2019.04.11), “Ширээний теннисний сонсголын бэрхшээлтэй иргэдийн тэмцээн” (“Цагийн хүрд” 2019.04.16) гэх мэтээр ярьж байх юм. Эдгээр өгүүлбэрүүд зөв найруулах зүйн дүрмийг бүгд зөрчсөн байна.

Эхний өгүүлбэрээс эхэлье. “Шатрын өсвөрийн дэлхийн аварга” гэжээ. “шатрын өсвөр”, “өсвөрийн дэлхий” гэж байхгүй. Ингэхээр хэн аварга болсон нь тодорхойгүй байна. Үүний оронд “Дэлхийн өсвөр шатарчдын аварга” гэвэл зөв болох байж. “Самбо бөхийн өсвөр үеийн олон хотын тэмцээн” гэхэд самбо бөхөөр өсвөр үеийн олон хот тэмцэлдсэн юм шиг ойлгогдоно. Энэ өгүүлбэрийг “Олон хотын өсвөрийн самбо чдын тэмцээн” гэвэл зөв болно. Дараагийн өгүүлбэр “19 хүртэлх насны Азийн аварга” гэж байна. 19 хүртэлх насны Ази байдаг юм шиг болсны зэрэгцээ тэр Азид нь хэн, ямар төрлөөр аваргалсан нь мэдэгдэхгүй байна. Иймээс эзэн биегүй өгүүлбэр болжээ. Бас “Монгол улсын хорь хүртэлх насны шигшээ баг” гэхэд тамирчид гэдэг үг хаягдсанаас болж алдаа гарчээ. Зүй нь “Монгол улсын хорь хүртэлх насны тамирчдын шигшээ баг ” гэвэл зөв болох байж. “Футзалын 19 хүртэлх насны улсын шигшээ баг ” гэсэн өгүүлбэрт Футзал нь 19 хүртэлх настай, тэр Футзал нь улсын шигшээ баг болсон мэт санаа гарч байна. Үүний оронд “Улсын 19 хүртэлх насны тамирчдын футзалын шигшээ баг” гэвэл дээр байжээ. “Шайбтай хоккейн өсвөрийн аварга шалгаруулах тэмцээн” гэхэд хоккейчдын аварга биш, хоккейн аварга шалгаруулах гэсэн утгатай болжээ. Амьгүй хоккей яаж аварга болох билээ. “Шатрын оюутны 2019 оны Улсын аварга шалгаруулах тэмцээн” гэсэн нь бас л буруу найруулга юм. Энэ өгүүлбэрийг “Улсын оюутан шатарчдын 2019 оны аварга шалгаруулах тэмцээн” гэвэл зөв болох байж.

Үндэсний олон нийтийн телевизийн спортын мэдээ бүхэн найруулгын ямар нэг алдаатай байх нь хэвшил болсон зүйл юм. “Шатрын өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээн”

гэснийг уншихад “шатрын өсвөр” гэж юу юм бэ? тэр нь яаж “улсын аварга” болох юм бэ? гэсэн эргэлзээ төрнө. Зүй нь “Улсын өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах тэмцээн” гэвэл дээр болох билээ. Бас “Боксын залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээн” гэхийн оронд “Улсын залуу боксчдын аварга шалгаруулах тэмцээн” гэвэл илүү ойлгомжтой болно. Үүнтэй адилхан буруу найруулгатай өгүүлбэр бол “Волейболын өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээн” гэсэн өгүүлбэр юм. “Өсвөрийн улсын аварга” биш “Өсвөрийн волейболчдын аварга” гэвэл оновчтой болох байж. Дээр дурдсанаас долоон дор, бүр инээд хүрмээр өгүүлбэр ч байна. Тухайлбал “Ширээний теннисний сонсголын бэрхшээлтэй иргэдийн тэмцээн” гэсэн байх юм. “Ширээний теннисний сонсголын бэрхшээл” гэж ямар бэрхшээл байдаг юм бол гэж гайхмаар. Энэ өгүүлбэрийг “Сонсголын бэрхшээлтэй иргэдийн ширээний теннисний тэмцээн” гээд найруулчихад тийм ч хэцүү биш баймаар санагдана. Зөв найруулах, оновчтой өгүүлэхийн эталон болж байх ёстой.

МҮОНТ-ийн мэдээний хэл ийм байхад арилжааны телевизүүдийн хэл найруулга муу байгааг шүүмжлэх нь бараг илүүц билээ. Тэдгээр телевизүүд “Бага насны улсын аварга шалгаруулах боксын тэмцээн” (TV-5. “Цаг” хөтөлбөр 2018.11.05), “Сонирхогчдын шатрын улсын аварга” (TV-5. “Цаг” хөтөлбөр 2018.11.05), “600 мянган шахмал түлш үйлдвэрлэнэ” (MNC телевиз 2019.04.-09), “220 мянган гэр хорооллын өрх” (NTV мэдээ. 2019.10.10), “Америкт 10 хоног алга болсон эмэгтэй олджээ” (MNC телевиз. 2019.04.11) гэх мэтээр ярьж, бичиж байна. Эдгээр өгүүлбэрийн алдааг дараах байдлаар залруулж

болно. “Бага насны улсын аварга шалгаруулах боксын тэмцээн” гэхэд “Бага насны улсын аварга” гэсэн санаа гарч байна. “Бага насны” гэдгийн ард хүн байх ёстой. Тэгэхээр “Бага насны боксчдын аварга” гэвэл зөв болно. Бас “Сонирхогчдын шатрын улсын аварга” гэхэд “Шатрын аварга” шалгаруулах гэсэн утга гарч байна. Шатар амьгүй учир аварга болж чадахгүй. Зүй нь “Шатар сонирхогчдын аварга” гэвэл зөв болно. “600 мянган шахмал түлш үйлдвэрлэнэ” гэхэд найруулгын хувьд зөв боловч баримтын алдаа гарсан байна. “600 мянга”-ын ард “тонн” гэдэг үг нэмбэл сая зөв болох байжээ. “220 мянган гэр хорооллын өрх” гэж ярих юм. Ингэж ярихад гэр хороолол нь 220 мянга юм шиг ойлгогдоно. Гэтэл өрх нь 220 мянга юм. Тэгэхээр “Гэр хорооллын 220 мянган өрх” гэвэл утга төгс болно. “Америкт 10 хоног алга болсон эмэгтэй олджээ” гэсэн өгүүлбэрт учир зүйн алдаа гарсан байна. Эмэгтэй анхнаасаа 10 хоног алга болохоор төлөвлөсөн юм шиг санаа гарч байна. Үүний оронд “Америкт алга болсон эмэгтэй 10 хоногийн дараа олджээ” гэвэл илүү ойлгомжтой болох байжээ. Энэ мэтээр телевизийн мэдээний хэл найруулга муу байгааг харуулах олон жишээг дурдаж болохоор байна. “Монгол хүн буруу ярьж, зөв ойлгодог” гэсэн улигт үгийг үгсийн сангаасаа авч хаяад үзэгч, сонсогчдоо хүндэтгэж, зөв ярьж, бичдэг болох цаг нэгэнт болжээ.

Эцэст нь телевизийн мэдээний бүтэц байгууламжид онцгой анхаарууштай хэдэн зүйл байгааг дурдвал:

1. Манай сэтгүүлч, сурвалжлагчид мэдээ толгойлох арга барилд хангалттай суралцахгүй байна. Ер нь мэдээ бичих шинэ арга барил эзэмшүүлэх богино хугацаатай сургалт, семинар үгүйлэгдэж байна.

2. Мэдээнд тусган үзүүлж байгаа объект заримдаа хэт жижгэрч орон нутгийн мэдээллийн хэрэгслээр нийтэлж, нэвтрүүлүүштэй, нийтэд хамаатай биш зүйл төв телевиз, радиогоор нэвтрэх удаа цөөнгүй байна. Бас мэдээний ашигтай байх шаардлага заримдаа хангагдахгүй байх нь үзэгддэг. Хувь хүний асуудал, эх үүсвэрийг нь заагаагүй мэдээлэл, хов живийн чанартай мэдээг төрийн мэдээллийн хэрэгслээс шахан гаргах нь зүйтэй юм.
3. Монголын үндэсний олон нийтийн телевизийн мэдээллийн хөтөлбөр хомсхон байна. Нэг мэдээг олон дахин давтдаг, мэдээллийн газар зүйн хамаарал жигд бус байгаа зэрэг нь мэдээллийн хөтөлбөрийн шуурхай, үр өгөөжтэй байх чанарыг сулруулж байна. Эх үүсвэрийг олшруулах, товч оновчтой болгох замаар багтаамжийг нэмэгдүүлэх хэрэгтэй санагддаг. Ялангуяа олон улсын мэдээ туйлын хомс байгаа нь бусад телевизтэй харьцуулахад илт мэдрэгдэж байна.
4. Мэдээнд зөвхөн баримтыг үнэн зөв тусгах чиглэлийг баттай барих нь сэтгүүл зүйн зарчимд нийцэх билээ. Өөрийн үзэл бодлыг хавчуулах, бусдын нэр төрд харшлах тайлбар зүүлт хийх явдал үзэгдсээр байгаа нь харамсалтай. 1997 оны ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны үеэр “Бүргэд” телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нэр дэвшигч Н.Багабанди халз маргааны үеэр өндөг шиг өөгүй цэвэрхэн хүн гэж өөрийгөө харуулахыг хичээлээ. Энэ хүн усан гахай жилтэй юм байна. Зурхайд зааснаар аз хийморь муутай, ажил үйлс нь бүтэмжгүй байх ажээ гэсэн утгатай зүйл ярьж байв. Энэ нь сэтгүүл зүйн ёс зарчмыг

зөрчсөн эвгүй хандлагын нэг жишээ юм.

5. Мэдээний хэл найруулга шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна. Уншаад өнгөрөхөд онц мэдрэгдэхгүй хэрнээ нэвтэрсэн мэдээний эхийг нарийвчлан үзвэл зөв найруулгатай өгүүлбэр цөөхөн үзэгдэж байна. Ялангуяа телевиз радиогийн хэлэнд, шаардлагагүй байхад гадаад үг хэллэг их хэрэглэж байгаа нь олон талаар муу үр дагаварт хүргэж болох эндэгдэл юм. Өнөөгийн сэтгүүл зүйд мэдээг дээдлэх чиглэл илэрхий давамгайлж, түүнийг бичих оновчтой, олон янзын хувилбарыг аль хэр эзэмшиж байгаагаар нь сэтгүүлчийн мэргэжлийн ур чадварыг хэмжих боллоо. Өнөөдөр мэдээллийг оновчтой, хураангуй болгох үүднээс төрөл зүйл жижгэрч, сэтгүүл зүйн материал үгийн тооцоонд захирагдаж, сонины хэл цахилгаан мэдээний хэлэнд шилжих үйл явц эхэлж байна. Энэ бол цахим техникийн эриний гол шинж, XXI зууны сэтгүүл зүйн үндсэн хандлага юм.

Эшлэл

- ¹ 2008. Даяаршил, хэлний бодлого, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл. УБ., 50 дахь тал.
- ² Норовсүрэн Л. 2008. Хянан найруулах ухаан. УБ., 49 дэх тал
- ³ Норовсүрэн Л. 2012. Фото сэтгүүл зүй. УБ., 195 дахь тал

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. 2008. Даяаршил, хэлний бодлого, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл. УБ.
2. Норовсүрэн Л. 2008. Хянан найруулах ухаан. УБ.
3. Норовсүрэн Л. 2012. Фото сэтгүүл зүй. УБ.
4. Мэндхүү Г, Өнөрсайхан Т. 2015 Мэргэжлийн телевиз. УБ.

5. Морли Д. 1982. Фотосъемка движения. М.
6. Карелина В. 1982. На экране и за экраном. М.
7. Шандрин В.С.1981. Фотографирование спорта. М.
8. Kenneth Kobre. 1996. PHOTO JOURNALISM: The professionals, approach. Butterworth-Heinemann., Greg Lewis. 1995. photojournalism: Content & Technique California

its national language and culture. Nowadays, there are a lot of linguistic errors in the news program of commercial broadcasting, including national public broadcasting. In particular, there are many sentence structure and word choice errors in the content of sports news on commercial and national public broadcasting. Wrong sentence structure and word choice contained in the content of sports news might remain in the mind of the audience and it may have negative effects on the linguistic usage of the public.

Summary

Each country pays more attention to the quality of the national language used in its national media as a part of the policy to protect